

# Гадаадын жолооны үнэмлэхтэй хүнд

## Японд жолоо барих арга зам

■ Японд жолоо барихын тулд, дараах үнэмлэхийн аль нэгтэй байх хэрэгтэй.

1) Японы жолооны үнэмлэх

2) Авто тээврийн тухай конвенц (1949 оны Женевийн конвенц)-д үндэслэсэн олон улсын жолооны үнэмлэх

\* Хэрэв жолооч нь Женевийн конвенцийн гэрээ байгуулаагүй улс, эсхүл Женевийн конвенцид орсон улс хэдий ч Женевийн конвенцийн заасан маягтаар олон улсын жолооны үнэмлэх гаргадаггүй бол тухайн улсын олон улсын жолооны үнэмлэхээр машин жолоодож болохгүй.

3) Гадаадын жолооны үнэмлэх

Гадаад ※1-н жолооны үнэмлэх (Засгийн газрын тогтоолоор хүлээн зөвшөөрсөн хүн ※2-н үйлдсэн япон хэлний орчуулгыг хавсаргасан байх.)

※1 Олон улсын жолооны үнэмлэх олгодоггүй улс орон эсвэл японтой ижил түвшинтэй нь хүлээн зөвшөөрөгдсөн жолооны үнэмлэхийн системтэй улс, орон нутаг (Эстони, Швейцарь, Герман, Франц, Бельги, Монако, Тайван (2020 оны 3-р сарын 1-ний байдлаар. Хамгийн сүүлийн үеийн мэдээллийн тухайд, орон нутгийн жолооны үнэмлэхийн төвөөс лавлана уу.)-н үнэмлэхтэй байх.

※2 Нотариатаар батлагдсан дараах хүнээр япон хэлнээс орчуулсан байхыг шаарддаг. Гадаадын хуульч орчуулагчдыг оруулахгүй.

1) Жолооны үнэмлэх олгох эрх бүхий гадаадын засаг захиргааны агентлагууд эсвэл гадаадын консулын газар (Гадаадын тусгай зөвшөөрөл олгох агентлагууд эсвэл тухайн улсад суугаа Японы элчин сайдын яам / консулын газар)

2) Замын хөдөлгөөний тухай хууль (Жолооны үнэмлэхтэй холбоотой хэсгийг хамруулна.)-д нийцсэн хууль тоогтоомжийн дагуу хариуцлага хүлээдэг гадаадын захиргааны байгууллагаас үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комисст хандаж гадаадын жолооны үнэмлэхийг япон хэл рүү албан ёсоор орчуулах нотариатын баталгаатай гадаадын корпораци эсвэл бусад этгээд болон үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн зохих байгууллагууд (Одоогийн байдлаар Тайванийн үнэмлэх олгодог Тайвань-Японы холбоо, Германы үнэмлэх олгодог Германы автомашины холбоо хүлээн зөвшөөрөгдсөн.)

3) Автомашин жолоодохтой холбогдуулан гадаадын захиргааны байгууллагаас олгосон жолооны үнэмлэхийн япон хэлний орчуулгыг албан ёсоор үйлдэхийг үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын орчуулга

(Одоогийн байдлаар, JAF (JAPAN AUTOMOBILE FEDERATION) хүлээн зөвшөөрөгдсөн байгаа.)

#### ■Японд жолоо барих хүчинтэй хугацаа

- 1) Японы жолооны үнэмлэх: Японы жолооны үнэмлэхэд бичигдсэн хүчинтэй хугацаанд
  - 2) Олон улсын жолооны үнэмлэх болон гадаадын жолооны үнэмлэх: Японы хилээр орсон өдрөөс эхлэн 1 жилийн дотор эсвэл тус жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацаанд (Гэвч, оршин суугчийн бүртгэлд бүртгэлтэй хүний тухайд японоос гарах болон японд дахиж орж ирэх зөвшөөрөл авсний дараа японоос гарч, 3 сарын дотор японд орж ирсэн бол, японы хилээр орж ирсэн өдрөөс эхэлж олон улсын жолооны үнэмлэхээр жолоо барих хүчинтэй хугацааг тоолохгүй. ※)
- ※ Олон улсын жолооны үнэмлэхээр жолоодож болох хүчинтэй хугацааны талаар хавсралт зургаас үзнэ үү.

#### Японы жолооны үнэмлэх авах арга

##### ■Гадаадын жолооны үнэмлэхтэй хүн,

- ① Замын хөдөлгөөний дүрэм болон автамашин жолоодлогын мэдлэгтэй
- ② Автамашин жолоодож байсан туршлагатай
- ③ Автамашин жолоодохтой холбогдох ур чадвартай

зэргийг үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комиссоос батлавал, японы замын хөдөлгөөний дүрмийн шалгалт болон ур чадварын шалгалтаас чөлөөлөгдөх бөгөөд гадаадын жолооны үнэмлэхээр жолоо барих боломжтой автомашины японы жолооны үнэмлэх авах боломжтой.

Нэмж дурдахад, Японтой ижил түвшинтэй нь хүлээн зөвшөөрөгдсөн жолооны үнэмлэхийн системтэй гадаадын жолооны үнэмлэхтэй хүн жолооны※ ур чадвар, дүрмийн шалгалтаас чөлөөлөгдөнө.

※ Исланд, Ирланд, АНУ (зөвхөн Виржиниа, Хавай, Мэрилэнд, Вашингтон орно.), Их Британи, Итали, Австрали, Австри, Нидерланд, Канад, Солонгос, Грек, Швейцарь, Швед, Испани, Словени, Чех, Дани, Герман, Шинэ Зеланд, Норвеги, Унгар, Финланд, Франц, Бельги, Польш, Португал, Монако, Люксембург, Тайван зэрэг 29 улс, бүс нутагт (2020 оны 3-р сарын 1-ний байдлаар. Хамгийн сүүлийн үеийн мэдээллийн тухайд, орон нутгийн үнэмлэхийн төвөөс лавлана уу).

## ■Өргөдөл өгөх газар

Японд оршин суугаа хаягт харъяалагдах орон нутгийн цагдаагийн газрын жолооны үнэмлэхийн төв зэрэг

## ■Анхаарах зүйлс

- 1) Гадаадын жолооны үнэмлэх авсны дараа, та дор хаяж 3 сар тухайн улсад байх ёстой (Хилээр гарч орсон тамгатай гадаад паспорт гэх мэтчилэн оршин суугаа хугацааг нотлох шаардлагатай.)
- 2) Өөр хүнээр төлөөлүүлэн өргөдөл гаргахыг хориглоно. Заавал та өөрөө өргөдлөө мэдүүлэх хэрэгтэй.

## ■Жолооны үнэмлэх мэдүүлэхэд шаардагдах бичиг баримт

### 1) Өргөдөл

※ Өргөдлийн хамт өвчний байдал зэргийг бичсэн “эрүүл мэндийн талаарх мэдүүлэг хуудас” (Англи, хятад зэрэг 11 улс орны хэл дээр) хавсаргасан байх шаардлагатай. Эрүүл мэндийн талаарх мэдүүлэх хуудасны асуултын дагуу, ажилтны зүгээс уг өвчний талаар дэлгэрэнгүйлэн асуух тохиолдол байдаг.

### 2) Өргөдөлд наах цээж зураг 1 ш

※ Өргөдөл мэдүүлэхээс 6 сарын өмнө авахуулсан малгайгүй (шашин шүтлэг, эмчилгээний шаардлагаас толгойгоо далдлах, даавуугаар ороох хэрэгтэй тохиолдлыг тооцохгүй), эгц харсан, арын фондгүй, цээжнээс дээш авахуулсан зураг байх. 3.0×2.4 см-н хэмжээтэй байна. Зурагны ар талд овог нэр, зураг авахуулсан огноог бичсэн байх.

### 3) Байнгын оршин суугаа газрын бүртгэлд бичигдсэн оршин суугчийн картын хуулбар (Оршин суугчийн бүртгэлгүй бол гадаад паспорт)

### 4) Эрүүл мэндийн даатгалын карт, миний дугаарын карт, гадаад иргэний карт г.м (үзүүлэх)

### 5) Гадаадын жолооны үнэмлэх (Олон улсын жолооны үнэмлэхийг дангаар нь авах боломжгүй.)

### 6) Дээр бичигдсэн бичиг баримтны япон хэл дээрх орчуулга (Нотариатаар батлагдсан хүн (P1※2)-р орчуулуулж, тухайн үнэмлэхээр жолоо барих боломжтой автомашины төрөл, үнэмлэхийн хүчинтэй хугацаа, үнэмлэхийн нөхцөлийг тодорхой бичсэн байх.)

### 7) Тус жолооны үнэмлэх авсны дараа, дор хаяж 3 сар тухайн улсад байсныг нотлох хилээр гарч орсон тамгатай гадаад паспортны бичиг

## 8) Хураамж

### ■Бусад


Өвчин, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой зөвлөмжийг тухайн орон нутгийн цагдаагийн зам тээврийн хэлтэст хүлээн авна.

Өргөдөл гаргах газар, хүлээн авах хугацаа, өргөдөл гаргахад шаардагдах бичиг баримт, хураамж гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийг та өргөдөл гаргаж байгаа орон нутгийн цагдаагийн жолооны үнэмлэхийн төвөөс авна уу.


# Олон улсын жолооны үнэмлэхээр жолоо барих боломжтой хугацаа

## 1 Оршин суугчийн бүртгэлд бүртгэгдээгүй хүн японд ирсэн бол

(1) Олон улсын жолооны үнэмлэх авсны дараа, анх удаа ирсэн бол




(2) Анх ирсэнээс хойш, олон улсын жолооны үнэмлэх авсан бол




## 2 Оршин суугчийн бүртгэлтэй хүн гадаадад гарч дахин японд орж ирсэн бол

(1) Гадаадад 3 сараас дээш хугацаанд байсны дараа дахин японд орж ирсэн бол



(2) Гадаадад 3 сар хүрэхгүй хугацаагаар байсны дараа дахин японд ирсэн бол (Гадаадын иргэдэд олон тохиолддог)



(3) Гадаадад 3 сар хүрэхгүй хугацаагаар байсны дараа дахин японд ирсэн бол (Япон иргэдэд олон тохиолддог)

